



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Зоонозын халдварт өвчний долоо хоног тутмын мэдээлэл

Дугаар №16



2018 оны 5-р сарын 07-11-ны хооронд

НЭГ. ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд 2018 оны 5 дугаар сарын 11-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчний сэжигтэй байж болзошгүй нийт **535** яаралтай дуудлагыг хүлээн авсан байна. Эдгээрийн 57(10.6%) галзуугийн эрсдэлд өртсөн, 471(88%) хачигт халдвар, 2(0.4%) бэтэг, 1(0.2%) хумхаа, 4(0.7%)-ийг боомын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол эзэлж байна.

1.1. Хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй тохиолдол:

Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Хөвсгөл, Ховд, Хэнтий, Дорнод, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Сэлэнгэ, Төв аймгийн 76 сум, нийслэлийн 7 дүүрэгт хачгаар дамжих халдварын 471 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 19.3%-иар буурсан, эпидемиологийн 18-р долоо хоногтой харьцуулахад 34%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.





5 дугаар сарын 11-ны өдрийн байдлаар хачигт риккетсиоз 22(4.7%), хачигт боррелиозын 8(1.8%) тохиолдлын онош тус тус батлагдаж, 43 тохиолдлын онош үгүйсгэгдээд байна.

Голомтот нутгийн хүн амд хачигт энцефалитын 8550 хүн тун вакциныг хүргүүлсэн. Эхний тунгийн хамралт 7412 (86.7%), давтан тунгийн хамралт 1138 (13%)-тай байна.

1.2. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол:

Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Завхан, Сэлэнгэ аймгийн 24 сум, нийслэлийн 4 дүүргээс галзуу өвчний эрсдэлд өртсөн нийт 57 тохиолдол мэдээлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 31.3%-иар буурсан. Эпидемиологийн 18-р долоо хоногт 2 тохиолдол бүртгэгдсэн.



1.3 Боомын хүний өвчний сэжигтэй тохиолдол:

Ховд, Төв, Дорнод аймгийн 3 суманд боомын арьсны хэлбэрийн хүний өвчлөлийн сэжигтэй 4 тохиолдол бүртгэгдсэн. Тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдэг, лабораторийн шинжилгээгээр тохиолдол үгүйсгэгдсэн байна.

1.4 Бэтгийн хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол:

Увс аймгийн Улаангом сум, нийслэлийн ХУД-ээс бэтэг өвчний онош тодруулахаар 2 хүний шинжилгээний материал ЗӨСҮТ-ийн лабораторит хүлээн аваад байна.

1.5 Хумхаа өвчний сэжигтэй тохиолдол:

Канад улсын иргэн. Өвчтөн “D” 34 настай, эмэгтэй. 2018 оны 3 дугаар сарын 16-29-ний хооронд Индонез улсад зорчих үедээ шумууланд хазуулсан өгүүлэмжтэй. 3 дугаар сарын 31-ний өдөр толгой өвдөх, дотор муухайрах, бүх бие янгинах, гүйлгэх шинж тэмдэг илэрч, Интермед эмнэлэгт 4 дүгээр сарын 01-ний өдөр хэвтсэн.

Хариу арга хэмжээ:

- Интермед эмнэлэгт 4 дүгээр сарын 01-ний 14 цагийн орчимд ЗӨСҮТ-ийн дуудлагын баг газар дээр нь очиж ажилласан.
- Өвчтнийг тусгаарлаж, хумхаа өвчний онош тодруулахаар сорьц дээжилж, ЗӨСҮТ-ийн лабораторид нян судлал, ийлдэс судлал, молекул биологийн шинжилгээгээр цусанд хумхаа өвчний үүсгэгчийн ДНХ тодорхойлогдоогүй онош үгүйсгэгдсэн.

1.5 Мэрэгч амьтны дуудлага:

2018 оны гарсаар нийслэлийн 6 дүүрэгт (БЗД, БГД, ХУД, СБД, СХД, ЧД)-ийн хэмжээнд нийт 17 удаагийн амьтны дуудлаганд үйлчилж, хураагдсан сорьц материалыг ЗӨСҮТ-ийн лабораторид шинжлэхэд тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчин үүсгэгч илрээгүй байна.

ХОЁР. ТУХАЙН 7 ХОНОГТ БҮРТГЭГДСЭН ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

Монгол улсад:

Мал, амьтны галзуу өвчин:

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Буудай багийн “Мядаг” гэдэг газар 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдөр малчин айлын 1 ямаанд мал амьтны галзуу өвчний шинж тэмдэг илэрч, дээж авч аймгийн МЭАЦЛ-ийн шинжилгээгээр галзуу өвчнөөр өвчилсөн болох нь тогтоогдсон. Тус суманд 5 дугаар сарын 04-нд өдөр сумын Засаг даргын захирамжаар хязгаарлалтын дэглэм тогтоосон байна.

Эх сурвалж: ОБЕГ

Африкийн гахайн халуурал өвчин: Украин улс

Украин улсын Киев хотын Обухив мужид африкийн гахайн халуурал өвчний улмаас, 8 гахай өртөмхий байснаас, 3 гахай өвчилж үхэн, 5 гахайг устгасан. Тус бүсэд хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Эх сурвалж: ДАЭМБ

Шувууны томуу өвчин: Финланд улс

Финланд улсын Турку хотын Лоунаис-Суоми мужийн шувууны аж ахуйд, шувууны томуугийн H5N6 вируст халдварын дэгдэлт бүртгэгдэж, 1 шувуу өвчилж үхсэн байна.

Хариу арга хэмжээ:

Голомтот хязгаарлалтын дэглэм тогтоож, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.



Эх сурвалж: ДАЭМБ

Эбола вирус халдвар: Бүгд Найрамдах Ардчилсан Конго улс

2018 оны 5 дугаар сарын 08-нд Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын Засгийн газраас эбола вирус шинэ халдвар Экваторын муж дахь Бикородод бүртгэгдэж, лабораторийн шинжилгээгээр 2 тохиолдол батлагдсан тухай зарласан байна.



Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын Эрүүл мэндийн яам 5 хүн тутмын 2 нь лабораторийн шинжилгээгээр эерэг дүнтэй байгааг Киншаса хотын Биомедитик үндэсний хүрээлэнгээс гаргаж, ДЭМБ-д мэдээлсэн байна. Шинжилгээнд илүү их дээж цуглуулж байна.

ДЭМБ, Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын Засгийн газартай хамтран, 2017 онд эбола вирус халдварын дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн төлөвлөгөөг ашиглан, үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.

ДЭМБ-ийн Шуурхай бэлэн байдал, хариу арга хэмжээний орлогч дарга Доктор Петер Салама хэлэхдээ “Бүгд Найрамдах Конго улсын Засгийн газрын гол анхаарах асуудал бол Бикортой хамтран ажиллах, эбола вирус дэгдэлт бүртгэгдсэн газар онцгой анхаарч, бэлэн байдлын хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна” гэж хэлэв.

ДЭМБ-ын мэргэжилтнүүдээс бүрдсэн баг “Хил хязгааргүй эмч нар” орон нутгийн Эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтнүүд Бикоро хотод ажиллахаар явсан. Бикоро хотын эрүүл мэндийн төв нь хязгаарлагдмал ба олон улсын хангалт дээр тулгуурладаг хангалт муутай.

Бикоро хот нь Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын зэргэлдээх Тамба нуурын эрэг орчмын экваторын мужид оршдог. Бикоро хотоос 30 километрийн зайд байрлах iloko Ironge ЭМБ-аа бүх тохиолдлыг анх мэдээлсэн.

Африк дахь ДЭМБ-ын бүсийн захирал Др. Мацидисио Моети хэлэхдээ "Энэхүү дэгдэлтийг шийдвэрлэхэд хамтарсан, тохирсон хариу арга хэмжээ авах шаардлагатай гэдгийг бид мэднэ. ДЭМБ нь хариу арга хэмжээний үйл ажиллагааны зардалд зориулж ЭМБ-ыг дэмжин, дээж авч, хавьтагчдыг тандаж, мэдээлэл цуглуулах болон түгээх аргачлалыг сайжруулна" гэж мэдэгдэв.

1976 онд эбола вирусыг илрүүлснээс хойш Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад бүртгэгдсэн 9 дэх удаагийн дэгдэлт юм. Сүүлийн 5 долоо хоногт ilkoko Iponge-д 21 сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, үүнээс 17 нас баралт бүртгэгдээд байна.

2017 онд авсан хариу арга хэмжээ

- Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад эбола вирусын дэгдэлтийн хамгийн сүүлийн тархалт 2017 онд хойд хэсэгт орших Likati Health Zone, Bas Uele мужид тус тус бүртгэгдэж байсан. Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын Засгийн газар, ДЭМБ болон өөр бусад олон байгууллагуудын хамтын зүтгэлээр хурдан тогтворжуулсан.
- 2017 онд эбола вирусын дэгдэлт гарахад үндэсний лабораторийн чадавхийг бэхжүүлсэнтэй холбоотой цусны дээжийг цаг тухайд нь шалгаж, Засгийн газраас нь дэгдэлт гарсан тохиолдолд дэгдэлтийг урьдчилан мэдэгдэж, орон нутгийн болон үндэсний хэмжээнд шуурхай хариу арга хэмжээ авч байсан.
- Мөн ЭМБ-д болон олон улсын байгууллагуудтай хамтарч дэмжлэг туслалцаа, санхүүжилтийг хурдан шуурхай хүргэх боломжоор хангаж байсан.
- ДЭМБ-ын дэмжлэг маш чухал бөгөөд тухайн дэгдэлт бүртгэгдснээс хойш 24 цагийн дотор зохион байгуулсан. ДЭМБ нь 50-аас дээш мэргэжилтнүүдийг Засгийн газар болон бусад хамтран ажиллах байгууллагуудад хамтран ажиллуулахаар илгээж байсан.
- Эбола вирусын эмчилгээ хийлгээгүй тохиолдолд аюултай. Эбола вирусын халдварын дундаж нас баралтын түвшин ойролцоогоор 50%-тай байна. Вирус нь зэрлэг амьтдаас хүнд, хүнээс хүнд дамжин тархдаг.

Эх сурвалж:ДЭМБ